



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Соронзонболд

-Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн гишүүд:

Ж.Алдаржавхлан

-Улсын Их Хурлын гишүүн

Р.Батболд

-Улсын Их Хурлын гишүүн

О.Батнайрамдал

-Улсын Их Хурлын гишүүн

Н.Батсүмбэрэл

-Улсын Их Хурлын гишүүн

Б.Жаргалан

-Улсын Их Хурлын гишүүн

Б.Мөнхсоёл

-Улсын Их Хурлын гишүүн

Б.Найдалаа

-Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг Ажлын хэсэг (Л.Соронзонболд)-т зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо (Р.Сэддорж)-нд даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ



Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн дугаар тогтоолын хавсралт

**“ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ БАТЛАХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ 21 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ,
ҮР ДҮНТЭЙ ТАНИЛЦАЖ, САНАЛ ДҮГНЭЛТ ГАРГАХ ҮҮРЭГ БҮХИЙ
АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

Нэг.Ажлын хэсгийн зорилго

1.1.Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 2 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн зорилго нь “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргахад оршино.

Хоёр.Ажиллах хугацаа, зохион байгуулалт

2.1.Ажлын хэсэг 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд ажиллана.

2.2.Ажлын хэсгийн үйл ажиллагааг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Л.Соронзонболд удирдан зохион байгуулна. Ажлын хэсэгт орсон Улсын Их Хурлын гишүүд хамтран ажиллана.

2.3.Ажлын хэсгийн гишүүн нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Улсын Их Хурлын 2021 оны 105 дугаар тогтоолоор батлагдсан Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллана.

2.4.Ажлын хэсэгт төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээ хийх болон мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

2.5.Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас ажлын хэсэгт хуралдааны тов хүргэх, ирц бүрдүүлэх, төрийн холбогдох байгууллагуудтай холбох, газар дээр нь танилцах зэрэг үйл ажиллагаанд шаардлагатай зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.

2.6.Ажлын хэсгийн хуралдах товыг Улсын Их Хурлын 7 хоногийн хэлэлцэх асуудлын тов, дараалалд тухай бүр урьдчилан оруулж хуралдана.

Гурав.Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх

3.1.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээ хийлгэх чиглэлээр Тамгын газрын холбогдох нэгжүүдийг татан оролцуулан хамтран ажиллана.

3.2.Бусад төрийн байгууллагын төлөөлөл болон Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын төлөөллийг шаардлагатай тохиолдолд тухай бүр татан оролцуулж болно.

Дөрөв.Гүйцэтгэх ажил, үе шат

4.1.Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг дүгнэхдээ дараах чиглэлээр холбогдох байгууллагаас мэдээлэл гаргуулан авч, танилцан дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт гаргана:

4.1.1.Зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд Засгийн газар хариуцан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн;

4.1.2.Зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад байгууллага хариуцан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн;

4.1.3.Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг үнэлж, үр дүнг нэгтгэн Улсын Их Хуралд танилцуулан дүгнэлт гаргасан байдал;

4.2.Ажлын хэсгийн гишүүд шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагын удирдлага, албан тушаалтантай уулзах, үйл ажиллагаатай танилцах, шаардлагатай мэдээ, мэдээлэл авч, санал солилцоно.

4.3.Ажлын хэсэг урьдчилсан бэлтгэл, хэрэгжилтийн дүн шинжилгээ, үнэлгээ хийх, санал дүгнэлт боловсруулж, танилцуулах гэсэн үе шатаар ажлыг гүйцэтгэнэ.

Тав.Тайлагналт, санхүүжилт

5.1.Ажлын хэсэг ажлын хэсгийн тайлан, санал дүгнэлтийг боловсруулан Байнгын хорооны хуралдаанд, шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

5.2.Ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд гарах болон бусад зардлыг холбогдох хууль, журамд заасны дагуу улсын төсвөөс санхүүжүүлнэ.

---oOo---